



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/А94

Булган сум

**Агентлаг, байгууллагын дарга нарын 2024 оны 7
гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэх тухай**

Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, 52.2, 52.3, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.9, 4.10, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээг хавсралтаар баталсугай.

2. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээг үндэслэн холбогдох журмын дагуу байгууллагын төсөвт багтаан зохих урамшуулал олгохыг тухайн байгууллагын төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6324011185

Аймгийн Засаг даргын 2024 оны
12- дугаар сарын 24- ны/ний өдрийн А/З.94 дугаар
захирамжийн хавсралт

Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, байгууллагуудын 2024 оны
гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ

Д/д	Агентлаг, байгууллагуудын нэр	Үнэлгээ хувиар
1	2	3
1	Аймгийн Засаг даргын Тамгын газар	94.6
2	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	98.3
3	Цагдаагийн газар	91.8
4	Шүүх шинжилгээний хэлтэс	91.3
5	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	92.1
6	Улсын бүртгэлийн хэлтэс	90.7
7	Татварын газар	97.7
8	Орон нутгийн өмчийн газар	96.5
9	Худалдан авах ажиллагааны газар	99.1
10	Хүнс, хөдөө аж ахуйн газар	95.0
11	Байгаль орчны газар	90.0
12	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	97.5
13	Мал эмнэлгийн газар	91.0
14	Статистикийн хэлтэс	97.3
15	Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс	94.0
16	Ус цаг уур, орчны шинжилгээний төв	91.0
17	Боловсролын газар	94.7
18	Эрүүл мэндийн газар	94.2
19	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	96.0
20	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	94.6
21	Нийгмийн даатгалын газар	97.5
22	Биеийн тамир, спортын газар	95.0
23	Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар	96.2
24	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс	94.3
25	Музей	93.3
26	Хөгжимт жүжгийн театр	95.4
27	Аймгийн Төв номын сан	94.6
28	Онцгой байдлын газар	96.2